

*“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2026 оны 05 сарын 06-ны өдрийн  
15 тоот тогтоолын хавсралт*

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН  
“ҮНЭТ ЦААСНЫ ИНДЕКС ТООЦОХ ЖУРАМ”  
*/Шинэчилсэн найруулга/*

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН  
ҮНЭТ ЦААСНЫ ҮНИЙН ИНДЕКС ТООЦОХ ЖУРАМ**

<b>НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ</b> .....	2
<b>ХОЁР.БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААСНЫ ИНДЕКС ТООЦОХ</b> .....	2
<b>ТОП-20 индексийн багц бүрдүүлэх</b> .....	2
<b>I болон II ангиллын индексийн багц бүрдүүлэх</b> .....	3
<b>Индекс тооцох аргачлал</b> .....	3
<b>ГУРАВ. БУСАД ЗАХ ЗЭЭЛД БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГСЭЛД СУУРИЛСАН ИНДЕКС ҮҮСГЭХ, ТҮҮНИЙГ ТООЦОХ</b> .....	5
<b>Индекс үүсгэх</b> .....	5
<b>Индексийн аргачлалд тавих шаардлага</b> .....	6
<b>Индексийн багцын бүрэлдэхүүнд тавих шаардлага</b> .....	6
<b>Индексийн засаглал</b> .....	7
<b>ДӨРӨВ.БУСАД</b> .....	8
<b>ФЬЮЧЕР ТЕК ИННОВЭЙШН ИНДЕКС ТООЦОХ АРГАЧЛАЛ</b> .....	9

## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ ИНДЕКС ТООЦОХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Үнэт цаасны индекс тооцох журам” (цаашид “Журам” гэх)-аар Монголын хөрөнгийн бирж (цаашид “МХБ” эсхүл “Бирж” гэх)-д бүртгэлтэй үнэт цаас болон гадаад биржид бүртгэлтэй үнэт цаас, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд суурилсан индекс үүсгэх, батлах, тооцох, нийтлэх, өөрчлөх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журамд орсон нэр томъёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:
  - 1.2.1. “индекс” гэж тухайн индексийн холбогдох аргачлал, шалгуурт үндэслэн сонгогдсон хөрөнгө оруулалтын хэрэгслүүдээс бүрдэх багцын гүйцэтгэл, үнэ цэнийн өөрчлөлтийг нэгтгэн хэмжиж, тухайн зах зээл, салбар, стратеги, эсхүл хөрөнгийн ангиллын жишиг гүйцэтгэлийг харуулах зорилготой тоон үзүүлэлтийг;
  - 1.2.2. “зах зээлийн үнэлгээ” гэж хувьцаат компанийн нийт эргэлтэд гаргасан үнэт цаасны тоо ширхгийг тухайн өдрийн үнэт цаасны арилжааны хаалтын ханшаар үржүүлж гаргасан үзүүлэлтийг;
  - 1.2.3. “арилжааны өдрийн дундаж гүйлгээ” гэж тухайн үнэт цаасны хагас жилийн арилжигдсан гүйлгээний үнийн дүнг (багцын арилжааг оруулахгүй) тухайн хугацаанд арилжаа явагдсан өдрийн тоонд харьцуулж гаргасан үзүүлэлтийг;
  - 1.2.4. “тохируулах коэффициент” буюу “adjustment factor (Adj)” гэж тухайн хувьцаат компанийн олон нийтэд чөлөөтэй арилжих хувьцааны тоо ширхгийг тухайн компанийн нийт гаргасан үнэт цаасанд нөлөөлүүлэх үзүүлэлтийг;
  - 1.2.5. олон нийтэд чөлөөтэй арилжигдах хувь (Free-float) гэж компанийн нийт гаргасан хувьцаанаас төрийн болон томоохон (нийт гаргасан хувьцааны 5 ба түүнээс дээш хувийг эзэмшигч) хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байгаа хувьцааг хассан тоо ширхгийг.
- 1.3. МХБ нь ТОП-20, үнэт цаасны бүртгэлийн I ба II ангиллын индекс болон энэ журамд заасан бусад индексийг тооцно.
- 1.4. Энэхүү журамд МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 1.5. Энэхүү журамд тусгагдсан тоон утгыг зуутын орны нарийвчлалаар ойлгоно.

### ХОЁР.БИРЖИД БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААСНЫ ИНДЕКС ТООЦОХ

#### ТОП-20 индексийн багц бүрдүүлэх

- 2.1 ТОП-20 индексэд энэхүү журмын 2.3 дугаар зүйлд заасан шалгуур хангасан, МХБ-д бүртгэлтэй 20 компани орно.
- 2.2 ТОП-20 индексийн багцыг өмнөх жилийн арилжааны мэдээн дээр үндэслэн жил бүрийн 1 дүгээр сарын эхний ажлын 10 өдөрт багтаан шинэчлэн тогтооно.
- 2.3 ТОП-20 индексийн багцад орох компанийг дараах аргачлалаар бүрдүүлнэ. Үүнд:
  - 2.3.1 МХБ дээр бүртгэлтэй бүх компанийг зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн Үнэт цаасны индекс тооцох журам

- дундаж гүйлгээ гэсэн 2 үзүүлэлтээр байр эзлүүлнэ.
- 2.3.2 Дээрх 2 үзүүлэлтийн хувьд тухайн компанийн эзэлсэн байраас аль ихийг сонгон дахин байр эзлүүлнэ. Энэхүү байр эзлүүлэлтээр хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан компаниудыг сонгон авна.
- 2.3.3 Хэрэв 2 компанийн үзүүлэлт ижил байвал зах зээлийн үнэлгээ өндөртэй компанийг сонгоно.
- 2.3.4 Индексийн багцад орох компанийн үнэт цаас нь МХБ-ийн үнэт цаасны арилжааны хоёрдогч зах зээлд жилийн нийт арилжааны өдрийн 20 хувиас доошгүй өдөрт арилжигдсан байна.
- 2.3.5 Хэрэв тухайн компанийн төрийн эзэмшил болон нийт гаргасан хувьцааны 5 ба түүнээс дээш хувийг эзэмшигч хөрөнгө оруулагчийн эзэмшил дэх хувьцааны нийлбэр нь нийт гаргасан хувьцааны 95 ба түүнээс дээш хувьтай тэнцүү бол уг компанийг ТОП-20 индексийн багцад оруулахгүй.
- 2.3.6 МХБ-ийн Захирлуудын зөвлөл нь МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниудын хууль, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр индексийн багцад орох, компанийн эрэмбэ дэх байр урагшлуулах, байр ухраах, индексийн багцаас хасах, индексийн багцад оруулах зэрэг шийдвэрийг хугацаа харгалзахгүй батлан хэрэгжүүлж индексийн багцад өөрчлөлт оруулна.

#### I болон II ангиллын индексийн багц бүрдүүлэх

- 2.4 I ангиллын индексийн сагсанд МХБ-ийн бүртгэлийн I ангилалд багтсан компаниудын үнэт цаас орно.
- 2.5 II ангиллын индексийн сагсанд МХБ-ийн бүртгэлийн II ангилалд багтсан компаниудын үнэт цаас орно.

#### Индекс тооцох аргачлал

- 2.6 МХБ-ийн ТОП-20 болон I, II дугаар ангиллын индекс тооцохдоо дор дурдсан дэс дарааллыг баримтална. Үүнд:

- 2.6.1 Индексийн багцад орсон компанийн зах зээлийн үнэлгээний жинг хязгаарлагч коэффициент  $W_n$ -ийг дараах  $f(W_n)$  функцийг ашиглан тооцно.

$$f(W_n) = \begin{cases} W_n = 1.0000 & \text{хэрэв } x \geq \frac{P_n * Q_{n,ff}}{\sum_{i=1}^n (P_n * Q_{n,ff})}; \\ & \text{эсвэл} \\ W_n = \frac{\left( \frac{x * \sum_{i=1}^s (P_s * Q_{s,ff})}{1 - (k - S) * x} \right)}{\left( \sum_{i=1}^n (P_n * Q_{n,ff}) \right)} & \text{хэрэв } x < \frac{P_n * Q_{n,ff}}{\sum_{i=1}^n (P_n * Q_{n,ff})} \end{cases}$$

- $Q_{n,ff}$  –  $n$  компанийн free-float хувьцааны тоо ширхэг,
- $P_n$  –  $n$  компанийн тухайн өдрийн ханш,
- $P_s$  – Индексийн багцад орсон, free-float хувьцаанд суурилсан зах зээлийн үнэлгээ нь индексийн багцын 'x' хувьтай тэнцүү ба түүнээс бага байх  $s$  компанийн ханш,
- $Q_{s,ff}$  - Индексийн багцад орсон, free-float хувьцаанд суурилсан зах зээлийн үнэлгээ нь индексийн багцын 'x' хувь ба түүнээс бага

- байх  $s$  компанийн *free-float* хувьцааны тоо ширхэг,
- $K$  – Индексийн багцад орсон нийт компанийн тоо,
- $S$  - Индексийн багцад орсон, *free-float* хувьцаанд суурилсан зах зээлийн үнэлгээ нь индексийн багцын 'х' хувь ба түүнээс бага байх компанийн тоо

- 2.6.2 Журмын 2.6.1-д тусгагдсан  $f(W_n)$  функцийн 'х' утга нь ТОП-20 индексийн хувьд 0.15, бүртгэлийн I ангиллын индексийн хувьд 0.35, бүртгэлийн II ангиллын индексийн хувьд 0.10 байна.
- 2.6.3 ТОП-20 индексийг арилжааны туршид тооцоолох бөгөөд индексийн хаалтын ханшийг индексийн багцад орсон компаниудын хаалтын ханшаар тооцоолно.
- 2.6.4 Индексийн багцад орсон компани бүрийн тохируулагч коэффициент Adjustment factor (Adj)-ийг олно.

$$Adj_n = \frac{Q_{n,ff}}{IQ_n} * W_n$$

- $Adj_n$  –  $n$  хувьцаат компанийн тохируулагч коэффициент,
  - $Q_n, ff$  –  $n$  хувьцаат компанийн *free-float* хувьцааны тоо ширхэг,
  - $IQ_n$  - Issued quantity буюу  $n$  хувьцаат компанийн нийт гаргасан хувьцааны тоо ширхэг,
  - $W_n$  –  $n$  хувьцаат компанийн индекст үзүүлэх нөлөөг хязгаарлагч
- 2.6.5 Индексийг дараах суурь томъёо ашиглан тооцно.

$$INDEX_{today} = \frac{\sum_{i=1}^n (IQ_n * P_n * Adj)}{Divisor} * Base Value$$

- $INDEX_{today}$  – Тухайн өдрийн индекс
  - $IQ_n$  – Issued quantity буюу  $n$  хувьцаат компанийн нийт гаргасан хувьцааны тоо ширхэг
  - $P_n$  – Price буюу  $n$  хувьцаат компанийн хувьцааны тухайн өдрийн ханш
  - $Adj$  – Adjustment factor буюу тохируулагч коэффициент
  - $Divisor$  – Хуваагч
  - $Base Value$  – Суурь нэгж
- 2.6.6 Индекс тооцох суурь томъёоны Base Value буюу суурь нэгж нь 19558,19 гэсэн тогтмол утгатай байна.
- 2.6.7 Индекс тооцох суурь томъёоны Divisor буюу хуваагчийг энэ журмын 2.2, 2.3.6, 2.6.8 болон 2.6.9-д заасан индексийн багцад өөрчлөлт хийгдэх бүрд дараах томъёоны дагуу шинэчлэн тогтооно.

$$Divisor_{new} = \sum_{i=1}^{new} (IQ_{new} * P_{new} * Adj_{new}) * \frac{Divisor_{old}}{\sum_{i=1}^{old} (IQ_{old} * P_{old} * Adj_{old})}$$

- $Divisor_{new}$  – Индексийн шинэ багцын хуваагч,
- $IQ_{new}, P_{new}, Adj_{new}$  – Индексийн шинэ багцад орсон компаниудын Нийт гаргасан хувьцааны тоо, Хувьцааны тухайн өдрийн ханш, Тухайн хувьцааны тохируулагч коэффициент,
- $Divisor_{old}$  – Индексийн хуучин багцын хуваагч,
- $IQ_{old}, P_{old}, Adj_{old}$  – Индексийн өмнөх багцад орсон компаниудын Нийт

*гаргаасан хувьцааны тоо, Хувьцааны хамгийн сүүлийн өдрийн ханш, Тухайн багцад орсон байсан хувьцааны тохируулагч коэффициент.*

- 2.6.8 МХБ-ийн Арилжааны алба нь индексийн багцад орсон компанийн тохируулагч коэффициент (Adj)-ийг бүх индексийн хувьд улирал бүрийн эхний 10 (арав) хоногт багтаан дахин тооцож, 2.6.1-д тусгагдсан  $f(W_n)$  функцийн 'х' утга нь ТОП-20 индексийн хувьд 0.20, бүртгэлийн I ангиллын индексийн хувьд 0.45, бүртгэлийн II ангиллын индексийн хувьд 0.15 байхаар тооцоход  $W_n$  үзүүлэлт 1.0000-ээс өөр утга авахаар байвал журмын 2.6.4-д заасан тохируулагч коэффициентыг дахин тооцно. Шаардлагатай тохиолдолд журмын 2.6.7-д заасан хуваагчийг дахин тооцож болно.
- 2.6.9 Бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэт цаасны тоо ширхэгт өөрчлөлт орох тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолыг үндэслэн МХБ-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр гарсан тухай бүр, мөн МХБ-ийн Захирлуудын зөвлөлөөс журмын 2.3.6-д тусгагдсан шийдвэр гарсан тохиолдолд журмын 2.6.1, 2.6.2, болон 2.6.7 дах заалтад тусгагдсан утгуудыг дахин тооцож 2.6.5-д тусгагдсан индексийн суурь томьёонд ашиглана.

## **ГУРАВ. БУСАД ЗАХ ЗЭЭЛД БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГСЭЛД СУУРИЛСАН ИНДЕКС ҮҮСГЭХ, ТҮҮНИЙГ ТООЦОХ**

### **Индекс үүсгэх**

- 3.1. МХБ нь шинэ бүтээгдэхүүн гаргалтыг дэмжих зорилгоор дангаар, эсхүл Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн бусад этгээдтэй хамтран бусад зах зээлд бүртгэлтэй үнэт цаас болон хөрөнгө оруулалтын хэрэгсэлд суурилсан шинэ индекс үүсгэн тооцож болно.
- 3.2. Шинэ индекс үүсгэх хүсэлтийг энэхүү журмын 3.1-д заасан этгээд Индексийн хороонд гаргана.
- 3.3. Шинэ индекс үүсгэх хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:
- 3.3.1 шинэ индекс үүсгэх тухай албан бичиг;
- 3.3.2 индексийн аргачлалын төсөл;
- 3.3.3 индексийн зорилго, индексээр төлөөлүүлэх зах зээл, салбар, стратеги, хөрөнгийн ангилал болон ашиглах цар хүрээний талаар танилцуулга;
- 3.3.4 индексэд багтах хөрөнгө оруулалтын хэрэгслийн хамрах хүрээ, сонгох шалгуур, хөрвөх чадвар, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хэт төвлөрөх эрсдэлийн үнэлгээ;
- 3.3.5 индексийн тооцоололд ашиглах ханшийн болон валютын өгөгдлийн албан ёсны эх сурвалж, өгөгдөл тасалдах, зах зээлийн саатал үүсэх үеийн зохицуулалтын санал;
- 3.3.6 тухайн индексэд суурилсан хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх болон бусад бүтээгдэхүүн гаргах болон хэрэгжих боломжийн товч үнэлгээ.
- 3.4. Индексийн хороо хүсэлтийг хянан хэлэлцэхдээ индексийн төлөөлөх чадвар, давтагдах болон хэрэгжих боломж, өгөгдлийн найдвартай байдал, аргачлалын ил тод байдал, засаглал, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэл, зах зээлийн шударга байдалд үзүүлэх нөлөөг үнэлж, санал, дүгнэлтээ МХБ-ийн Гүйцэтгэх захиралд хүргүүлнэ.

### **Индексийн аргачлалд тавих шаардлага**

- 3.5 Бусад зах зээлд бүртгэлтэй үнэт цаас болон хөрөнгө оруулалтын хэрэгсэлд суурилсан индекс бүр тусдаа тооцоолох аргачлалтай байх бөгөөд уг аргачлалыг энэхүү журмын хавсралтаар батална.
- 3.6 Индексийн аргачлалд дараах зүйлсийг заавал тусгана:
  - 3.6.1 индексийн нэр, индекс үүсгэх зорилго, индексийг ашиглах цар хүрээ;
  - 3.6.2 индексээр төлөөлүүлэх зах зээл, салбар, стратеги, газар зүй, хөрөнгийн ангилал;
  - 3.6.3 индексийн хамрах хүрээ, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд тавих нийтлэг болон тусгай шалгуур, хасах нөхцөл;
  - 3.6.4 индексийн багцын бүрэлдэхүүнийг сонгох дараалал, сонгох өгөгдөл, үнэлгээний шалгуур, орлуулах зохицуулалт буюу үнэт цаасыг сонгох журам;
  - 3.6.5 индексийн багцын хувийн жин тогтоох арга, жингийн дээд хязгаар, төвлөрлийн хяналт, дахин тэнцвэржүүлэх болон шинэчлэх журам;
  - 3.6.6 суурь огноо, суурь утга, тооцоолох томъёо, индексийн төрөл, хуваагч болон тохируулгын журам;
  - 3.6.7 индексийн тооцоололд ашиглах үнийн болон валютын албан ёсны эх сурвалж, өгөгдлийн эрэмбэ, өгөгдөл тасалдах үеийн орлуулан ашиглах дараалал;
  - 3.6.8 индексийг тооцоолох давтамж, нийтлэх хугацаа, хэлбэр, мэдээлэх суваг;
  - 3.6.9 компанийн үйл ажиллагаа, зах зээлийн саатал, онцгой нөхцөл байдал, тооцооллын алдаа, дахин тооцооллын үед баримтлах журам;
  - 3.6.10 индексийн засаглал, индекс тооцогч, индексийн администраторын чиг үүрэг, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх зохицуулалт;
  - 3.6.11 аргачлалд өөрчлөлт оруулах, мэдээлэх, хүчин төгөлдөр болох нөхцөл, өөрчлөлтийн түүх хөтлөх журам;
  - 3.6.12 индексийг түр зогсоох, зогсоох нөхцөл, сүүлийн утгыг тогтоох болон хэрэглэгчдэд мэдээлэх журам.

### **Индексийн багцын бүрэлдэхүүнд тавих шаардлага**

- 3.7 Индексийн багцын бүрэлдэхүүнд оруулах хөрөнгө оруулалтын хэрэгсэл нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:
  - 3.7.1 Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын гишүүн улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй, чөлөөтэй арилжаалагддаг байх;
  - 3.7.2 индексийн зорилго, хамрах хүрээ, төлөөлөх чадвар болон хөрөнгө оруулалтын стратегид нийцсэн байх;
  - 3.7.3 бүртгэлээс хасагдах, арилжаа зогсох, татан буугдах, эсхүл бодлогоо бүхэлд нь өөрчлөх нөхцөл байдал үүсээгүй байх;
  - 3.7.4 арилжааны тоо хэмжээ, үнийн дүн, хаалтын ханш, хөрөнгө оруулалтын бодлого, компанийн үйл ажиллагаа болон үнэт цаастай холбоотой мэдээллийг баталгаат эх сурвалжаас тогтмол авах боломжтой байх;
  - 3.7.5 индексэд суурилсан бүтээгдэхүүн гаргах, багцыг дагаж хэрэгжүүлэхэд ноцтой саад учруулахгүй хөрвөх чадвартай байх.
- 3.8 Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгө оруулалтын санболон түүнтэй адилтгах бүтээгдэхүүнийг индексийн багцад оруулах бол тухайн бүтээгдэхүүний хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгийн бүтэц, цэвэр хөрөнгийн үнэлгээ, багцын мэдээллийн ил тод байдал, давхардсан болон хэт төвлөрсөн эрсдэлийг харгалзан үзнэ.
- 3.9 Бирж нь индексийн төрөл, зорилго, хэрэгжих боломжоос хамааран зах зээлийн үнэлгээ, олон нийтэд чөлөөтэй арилжаалагдах хувь хэмжээ, өдрийн дундаж

арилжааны хэмжээ, арилжаалагдсан өдрийн тоо, улс, салбар, үнэт цаас гаргагч, бүтээгдэхүүн, хөрөнгийн ангиллын дээд хэмжээ, хөрөнгө оруулалтын болон эрсдэлийн нэмэлт шалгуурыг аргачлалаар тогтоож болно.

- 3.10 Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн суурь индексийн багцын бүрэлдэхүүн нь нэг бүтээгдэхүүнд хэт төвлөрөхгүй байх зохицуулалттай байна.

### **Индексийн засаглал**

- 3.11 Бирж нь индекс үүсгэх, тооцох, нийтлэх, өөрчлөх, түр зогсоох, зогсоох ажиллагаанд хяналт тавих зорилгоор Индексийн хороог байгуулна.
- 3.12 Индексийн хороо нь 3-аас доошгүй 7-оос дээшгүй, сондгой тооны бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүд нь хөрөнгийн зах зээл, үнэт цаас, хөрөнгө оруулалт, санхүүгийн шинжилгээ, эрсдэлийн удирдлага, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны чиглэлээр мэдлэг, туршлагатай байна. Хорооны бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй хувийг хараат бус гишүүн бүрдүүлнэ.
- 3.13 Индексийн хороо нь дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:
- 3.13.1 шинэ индекс үүсгэх хүсэлт болон аргачлалыг хянах, санал, дүгнэлт гаргах;
  - 3.13.2 аргачлалд оруулах материаллаг өөрчлөлтийн үндэслэл, нөлөөллийг дүгнэх;
  - 3.13.3 холбогдох индексийн аргачлалд заасны дагуу индексийн багцын бүрэлдэхүүнийг шинэчлэх, индексийн багцыг дахин тэнцвэржүүлэх, зах зээлийн саатал, онцгой нөхцөл байдал, тооцооллын алдаа, дахин тооцоолол, индексийг түр зогсоох, бүр зогсоох болон тухайн индексийн аргачлалд индексийн хорооноос шийдвэрлэхээр заасан бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;
  - 3.13.4 индексийн төлөөлөх чадвар, хэрэгжих боломж, өгөгдлийн чанар, аргачлалын үр нөлөөг тогтмол хянах;
  - 3.13.5 ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, бууруулах, зохицуулах талаар дүгнэлт гаргах.
- 3.14 Индексийн хорооны ажиллах журмыг МХБ-ийн Гүйцэтгэх захирал батална.

### **Индексийг тооцох, нийтлэх, хянах**

- 3.15 Бирж нь батлагдсан индексийн аргачлалын дагуу индексийн багцад багтсан хөрөнгө оруулалтын хэрэгслийн хаалтын ханшийг албан ёсны баталгаат эх сурвалжаас, гадаад валютын ханшийн өгөгдлийг Монголбанкны албан эх сурвалжаас авч, индексийг тооцоолж, нийтэд мэдээлнэ.
- 3.16 Индексийн аргачлал, Индексийн хорооны бүрэлдэхүүн, индексийн түвшин, шинэчлэлт, дахин тэнцвэржүүлэлт, материаллаг өөрчлөлт, зах зээлийн саатал, онцгой нөхцөл байдлын улмаас гаргасан шийдвэр болон бусад холбогдох мэдээллийг Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
- 3.17 Хуваарьт шинэчлэлт болон дахин тэнцвэржүүлэлтийн шийдвэрийг аргачлалд заасан хугацаанд урьдчилан нийтэд мэдээлэх бөгөөд хуваарьт бус өөрчлөлтийг шийдвэр гаргаснаас хойш боломжит хамгийн богино хугацаанд нийтэд мэдээлнэ.
- 3.18 МХБ-ээс тооцон мэдээлж буй гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаас болон хөрөнгө оруулалтын хэрэгсэлд суурилсан индекс тус бүрийг Индексийн хороо улирал тутам хянаж, жилд нэгээс доошгүй удаа аргачлал, өгөгдлийн чанар, индексийн зорилгод нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийнэ.
- 3.19 Индексийн хяналт, шинжилгээний үр дүнд өөрчлөлт оруулах, аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүссэн бол энэхүү журам болон тухайн индексийн аргачлалд заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

## ДӨРӨВ.БУСАД

- 4.1 Индексийн мэдээллийг Бирж тухайн индексийн аргачлалд заасан давтамж, хугацаагаар өөрийн цахим хуудас болон бусад мэдээллийн сувгаар нийтэд мэдээлнэ.
- 4.2 Бирж нь индексийн аргачлалд оруулсан материаллаг өөрчлөлт, дахин тооцоолол, индексийг түр зогсоох, зогсоох, хуваарьт бус шинэчлэлт, дахин тэнцвэржүүлэлттэй холбоотой мэдээллийг шийдвэр гарсан даруй нийтэд мэдээлнэ.
- 4.3 Бирж нь энэ журамд заасан индексийг бусдад төлбөртэйгөөр ашиглуулах бол Гүйцэтгэх захирал төлбөрийг тогтоож, гэрээ байгуулсны үндсэн дээр ашиглуулна.
- 4.4 Индексийг мэдээлэхдээ тухайн өдрийн индексийн үзүүлэлтийг өмнөх өдрийн үзүүлэлттэй харьцуулна. Хэрэв өссөн тохиолдолд нэмэх (+) тэмдэг, буурсан тохиолдолд хасах (-) тэмдгийг тус тус нэгжийн өмнө тэмдэглэн үзүүлнэ.
- 4.5 Индексийн өгөгдөлд өөрчлөлт оруулах, индексийн багцыг шинэчлэх, дахин тэнцвэржүүлэх, дахин тооцоолол хийх ажлыг МХБ-ийн Арилжааны алба нь Мэдээллийн технологийн албатай хамтран индексийн аргачлалд нийцүүлэн гүйцэтгэнэ.
- 4.6 МХБ-ийн хяналт шалгалт хариуцсан алба энэхүү журмын хэрэгжилт, индексийн засаглалд холбогдох хууль тогтоомж, журам, гэрээнд заасны дагуу хяналт шалгалт хэрэгжүүлнэ

---oOo---

## ФЬЮЧЕР ТЕК ИННОВЭЙШН ИНДЕКС ТООЦОХ АРГАЧЛАЛ

### 1. Индексийн зорилго

“Фьючер Тек Инновэйшн Индекс” (цаашид “Индекс” гэх) нь АНУ-ын хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт 17 /арван долоо/ хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан /цаашид “БАС” гэх/-ийн нэгж эрхээс бүрдэх бөгөөд АНУ-ын хувьцааны зах зээл болон технологи, инновацын чиглэл, тэдгээрийн нийлүүлэлтийн сүлжээний чухал бүрэлдэхүүн болох түүхий эд, эрчим хүчний салбарт чиглэсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг төлөөлөх жишиг үзүүлэлт байна.

### 2. Индексийн багц бүрдүүлэх

#### *Индексийн багцын хуваарилалт*

2.1 Индексийн багцыг дор дурдсан стратегийн болон дэд стратегийн чиглэлийн дагуу хөрөнгө оруулалт хийдэг БАС-гаас бүрдүүлэх бөгөөд стратегийн чиглэл тус бүрийн хувьд индексийн багцад хувийн жинг дараах байдлаар тогтооно. Үүнд:

- 2.1.1 АНУ-д үйл ажиллагаа явуулдаг, зах зээлийн үнэлгээний эрэмбээр эхний 500-д багтах компаниудын хувьцаанд тэнцүү хувийн жингээр хөрөнгө оруулдаг БАС-гийн Индексийн багцад эзлэх хувийн жин нь 30 хувь байна.
- 2.1.2 Технологийн салбарт чиглэсэн стратегийн хөрөнгө оруулалт нь дараах дэд стратегийн чиглэл, хувийн жинтэй байна:
  - 2.1.2.1 Насдакийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, зах зээлийн үнэлгээний эрэмбээр эхний 100-д багтах санхүүгийн бус компанийн хувьцаанд хөрөнгө оруулдаг БАС-гийн Индексийн багцад эзлэх хувийн жин 30 хувь байна;
  - 2.1.2.2 Хиймэл оюун ухааны салбарт голлон хөрөнгө оруулдаг БАС-гийн Индексийн багцад эзлэх хувийн жин 5 хувь байна;
  - 2.1.2.3 Чип үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн салбарт голлон хөрөнгө оруулдаг БАС-гийн Индексийн багцад эзлэх хувийн жин 5 хувь байна;
  - 2.1.2.4 Батлан хамгаалахын салбарт голлон хөрөнгө оруулдаг БАС-гийн Индексийн багцад эзлэх хувийн жин 5 хувь байна;
  - 2.1.2.5 Роботик болон автоматжуулалтын салбарт голлон хөрөнгө оруулдаг БАС-гийн Индексийн багцад эзлэх хувийн жин 2.5 хувь байна;
  - 2.1.2.6 Кибер аюулгүй байдлын салбарт голлон хөрөнгө оруулдаг БАС-гийн Индексийн багцад эзлэх хувийн жин 2.5 хувь байна.
- 2.1.3 Эрчим хүчний салбарт чиглэсэн стратегийн хөрөнгө оруулалт нь дараах дэд стратегийн чиглэл, хувийн жинтэй байна:
  - 2.1.3.1 Эрчим хүчний салбарт голлон хөрөнгө оруулдаг БАС-гийн Индексийн багцад эзлэх хувийн жин 10 хувь байна.
- 2.1.4 Таваарын бүтээгдэхүүнд суурилсан стратегийн хөрөнгө оруулалт нь дараах дэд стратегийн чиглэл, хувийн жинтэй байна:
  - 2.1.4.1 Таваарын бүтээгдэхүүнд голлон хөрөнгө оруулдаг БАС-гийн Индексийн багцад эзлэх хувийн жин 10 хувь байна.

#### *Индексийн хамрах хүрээ, багцын бүрэлдэхүүнд тавих шалгуур*

2.2 Индексийн багцад оруулах бүтээгдэхүүн нь дараах үндсэн шалгуурыг хангасан байна:

- 2.2.1 Багцыг бүрдүүлэх БАС нь дараах гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй байна. Үүнд:
- 2.2.1.1 Насдакийн хөрөнгийн бирж (Nasdaq Exchange);
  - 2.2.1.2 Нью-Йоркийн хөрөнгийн бирж (NYSE Arca Exchange);
  - 2.2.1.3 Сбое BZX хөрөнгийн бирж (Сбое BZX Exchange).
- 2.2.2 Тухайн БАС-гийн хөрөнгө оруулалтын стратегийн чиглэл нь Индексийн зорилго болон стратегийн хөрөнгө оруулалтын чиглэлтэй нийцсэн байх;
- 2.2.3 Тухайн БАС-гийн активын хэмжээ нь 200.0 /хоёр зуу/ сая ам.доллараас доошгүй байх;
- 2.2.4 Тухайн бирж дээр бүртгэгдсэнээс хойш сүүлийн 6 /зургаа/-аас доошгүй сарын хугацаанд тогтмол арилжигдсан байх;
- 2.2.5 Тухайн БАС-гийн сүүлийн 3 сарын өдрийн дундаж арилжааны үнийн дүн нь 1.0 /нэг/ сая ам.доллараас доошгүй байх.

Индексийн хамрах хүрээг Хавсралт №02-д заасны дагуу тодорхойлсон ба Индексийн хороо нь уг жагсаалтад жилд хоёр удаа өөрчлөлт оруулж болно.

#### *Индексийн багцыг сонгох аргачлал*

2.3 Индексийн багцад оруулах БАС-г энэхүү аргачлалын 2.1-д заасан стратегийн болон дэд стратегийн ангилал тус бүрийн хүрээнд Индексийн хамрах хүрээнд багтсан БАС-гуудаас дор дурдсан аргачлалын дагуу сонгоно:

2.3.1 Энэхүү аргачлалын 2.1.1-д заасан зах зээлийн үнэлгээний эрэмбээр эхний 500-д багтах компаниудын хувьцаанд тэнцүү хувийн жингээр хөрөнгө оруулдаг БАС-гаас Индексийн багцад оруулах үндсэн болон орлуулах БАС-г дараах байдлаар сонгоно. Үндсэн БАС татан буугдах, эсхүл хөрөнгө оруулалтын стратегия эрс өөрчилсөн тохиолдолд түүний оронд орлуулах БАС-г Индексийн багцад оруулна.

Төрөл	БАС-гийн нэр	БАС-гийн тикер
Үндсэн БАС	The Goldman Sachs Equal Weight U.S. Large Cap Equity ETF	GSEW
Орлуулах БАС	Invesco S&P 500® Equal Weight ETF	RSP

2.3.2 Энэхүү аргачлалын 2.1.2.1-т заасан Насдакийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, зах зээлийн үнэлгээний эрэмбээр эхний 100-д багтах санхүүгийн бус компанийн хувьцаанд хөрөнгө оруулдаг БАС-гаас Индексийн багцад оруулах үндсэн болон орлуулах БАС-г дараах байдлаар сонгоно. Үндсэн БАС татан буугдах, эсхүл хөрөнгө оруулалтын стратегия эрс өөрчилсөн тохиолдолд түүний оронд орлуулах БАС-г Индексийн багцад оруулна.

Төрөл	БАС-гийн нэр	БАС-гийн тикер
Үндсэн БАС	The Invesco NASDAQ-100® ETF	QQQM
Орлуулах БАС	Invesco QQQ Trust <sup>SM</sup> , Series 1	QQQ

2.3.3 Энэхүү аргачлалын 2.1.2.2-2.1.2.6 болон 2.1.3.1-д заасан стратегийн дэд чиглэлүүдэд хөрөнгө оруулдаг БАС-гуудаас Индексийн багцад оруулах БАС-г дараах аргачлалын дагуу сонгоно:

#### **БАС-г үнэлэх**

2.3.3.1 БАС тус бүрийн хувьд доорх хүснэгтэд багтсан үзүүлэлтүүдийг тооцож, нормалчилан, харгалзах хувийн жинд үндэслэн нийлмэл оноог гаргана.

2.3.3.2 Доорх хүснэгтэд заасан 1-3 дугаартай үзүүлэлтүүдийг БАС тус бүрийн сүүлийн 3 жилийн түүхэн өгөгдөлд үндэслэн тооцно. Тухайн БАС нь үүсгэн байгуулагдсан, эсхүл холбогдох биржид бүртгэгдэн арилжигдаж эхэлснээс хойш 3 /гурав/ жил болоогүй тохиолдолд сүүлийн 1 /нэг/ жилээс доошгүй хугацааны түүхэн өгөгдөлд үндэслэн тооцно.

№	Үзүүлэлт	Томьёо	Үзүүлэлтийг нормалчил ах томьёо	Жин	Товч тайлбар
1	Шарпын харьцаа үзүүлэлт (Sharpe ratio)	$\frac{R_p - R_f}{\sigma_p}$	$\frac{X_i - X_{min}}{X_{max} - X_{min}}$	20.0%	Энэ нь нэгж эрсдэл (эерэг болон сөрөг ханшийн хэлбэлзэл)-д ногдох өгөөжийн хэмжээг илэрхийлнэ. Уг үзүүлэлт өндөр байх тусам тухайн БАС нь эрсдэлтэй харьцуулахад илүү үр ашигтай гүйцэтгэл үзүүлсэн гэж үнэлнэ.
2	Сортино харьцаа үзүүлэлт (Sortino ratio)	$\frac{R_p - R_f}{\sigma_d}$	$\frac{X_i - X_{min}}{X_{max} - X_{min}}$	20.0%	Энэхүү нь БАС-гийн ханшийн зөвхөн сөрөг хэлбэлзлийг эрсдэл гэж үзэн, нэгж уналтын эрсдэлд ногдох өгөөжийг хэмжих үзүүлэлт юм. Энэ нь доош чиглэсэн эрсдэлийг илүү бодитой үнэлдэг бөгөөд тус үзүүлэлт өндөр байх тусам тухайн БАС нь уналтын үед илүү тогтвортой гүйцэтгэл үзүүлсэн гэж үзнэ.
3	Хамгийн өндөр уналтын хувь хэмжээ (Maximum Drawdown)	$\frac{Peak - Through}{Peak}$	$\frac{X_i - X_{min}}{X_{max} - X_{min}}$	20.0%	Энэхүү үзүүлэлт нь тухайн хугацаанд БАС-гийн ханш хамгийн өндөр түвшинд (Peak) хүрснээс хойш хамгийн доод түвшин (Trough) хүртэл хэдэн хувиар буурсныг хэмжинэ.
4	Шинжээчдийн нэгдсэн дундаж өсөлтийн хүлээлт (Analyst Implied Growth)	$\frac{WAP_{target} - WAP_{cu}}{WAP_{current}}$	$\frac{X_i - X_{min}}{X_{max} - X_{min}}$	40.0%	Энэхүү үзүүлэлт нь Үнэлгээний өдрийн байдлаарх тухайн БАС-гийн багцад орсон хувьцаануудын жигнэсэн дундаж ханш (weighted average market price)-г тухайн хувьцаануудын шинжээчдийн нэгдсэн зорилтот ханш (consensus target price)-тай харьцуулж, тухайн БАС-гийн багцын түвшний өсөлтийн боломжийг тооцон илэрхийлнэ. Тус үзүүлэлт нь өндөр байх тусам тухайн БАС-г Үнэлгээний өдрийн байдлаар өсөлт үзүүлэх боломжтой багц эзэмшиж байна гэж үзнэ.

Тайлбар:

- $R_p$ : Тухайн хугацааны дундаж өгөөж
- $R_f$ : Эрсдэлгүй хүү. Үүнийг АНУ-ын Засгийн газрын 3 сарын хугацаатай Төрийн сангийн үнэт цаас (3-month U.S. Treasury Bill)-ны өгөөжийн дундаж үзүүлэлтээр төлөөлүүлэн тооцно.
- $\sigma_p$ : Нийт стандарт хэлбэлзэл
- $\sigma_d$ : Зөвхөн сөрөг өгөөжийн стандарт хэлбэлзэл

- $X_i$ : Тухайн БАС-гийн холбогдох үзүүлэлт
- $WAP_{target}$ : Тухайн БАС-гийн хөрөнгө оруулалтын багц дахь хувьцаа бүрийн хувьд шинжээчдийн нэгдсэн зорилтот үнийг хувийн жингээр үржүүлэн тодорхойлно
- $WAP_{current}$ : Үнэлгээний өдрийн байдлаарх тухайн БАС-гийн хөрөнгө оруулалтын багцын жигнэсэн дундаж үнэлгээ

### Нийлмэл оноонд үндэслэн дэд стратегийн чиглэл бүрээс төлөөлөх БАС-г сонгох

2.3.3.3 Энэхүү аргачлалын 2.1.2.2-2.1.2.6 болон 2.1.3.1-д заасан стратегийн дэд чиглэл тус бүрийн хувьд тухайн дэд чиглэлийн ангилалд багтсан БАС-гуудыг нийлмэл онооны дарааллаар эрэмбэлж, хамгийн өндөр нийлмэл оноо бүхий 2 /хоёр/ БАС-г сонгоно.

### Индексийн багцад орох БАС-г тодорхойлох

2.3.3.4 Энэхүү аргачлалын 2.3.3.3-т заасны дагуу сонгогдсон БАС-г тухайн стратегийн дэд чиглэлийг төлөөлөх БАС-гаар тооцож, Индексийн багцад оруулна.

2.3.3.5 Индексийн багцад оруулах БАС нь тухайн стратегийн дэд чиглэлийн ангилалд багтсан нийт БАС-гийн нийлмэл онооны дундаж үзүүлэлтээс доошгүй оноотой байна.

2.3.4 Энэхүү Индексийн аргачлалыг батлах үеийн байдлаар Индексийн хамрах хүрээнд багтсан БАС-гуудаас сонгосон эхлэлийн Индексийн багц дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

№	Стратегийн чиглэл	БАС-гийн нэр	БАС-гийн тикер	Индексийн багцад эзлэх хувийн жин
<b>1</b>	<b>АНУ-ын зах зээлийн үнэлгээгээр хамгийн том 500 орчим ХК-ийн хувьцааг тэнцүү хувийн жинтэйгээр агуулсан хөрөнгө оруулалт</b>			<b>30.0%</b>
1.1	АНУ-ын хамгийн том 500 хувьцаат компанийн хувьцаанд суурилсан хөрөнгө оруулалт	The Goldman Sachs Equal Weight U.S. Large Cap Equity ETF	GSEW	30.0%
<b>2</b>	<b>Технологийн салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт</b>			<b>50.0%</b>
2.1	Ерөнхий технологийн салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт	The Invesco NASDAQ-100® ETF	QQQM	30.0%
2.2	Хиймэл оюун ухааны салбар	Global X Artificial Intelligence & Technology ETF	AIQ	2.5%
		The Roundhill Generative AI & Technology ETF	CHAT	2.5%
2.3	Чип үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн салбар	VanEck Semiconductor ETF	SMH	2.5%
		The Invesco PHLX Semiconductor ETF	SOXQ	2.5%
2.4	Батлан хамгаалахын салбар	Global X Defense Tech ETF	SHLD	2.5%
		The Select STOXX® Europe Aerospace & Defense ETF	EUAD	2.5%
2.5	Роботик болон автоматжуулалтын салбар	ROBO Global Robotics & Automation ETF	ROBO	1.25%
		ARK Autonomous Tech. & Robotics ETF	ARKQ	1.25%
2.6	Кибер аюулгүй байдлын салбар	First Trust NASDAQ Cybersecurity ETF	CIBR	1.25%
		The Amplify Cybersecurity ETF	HACK	1.25%
<b>3</b>	<b>Таваарын бүтээгдэхүүнд суурилсан хөрөнгө оруулалт</b>			<b>10.0%</b>

3.1	Таваарын бүтээгдэхүүнд суурилсан хөрөнгө оруулалт	Global X Copper Miners ETF	COPX	10.0%
<b>4</b>	<b>Эрчим хүчний салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт</b>			<b>10.0%</b>
4.1	Эрчим хүчний салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт	Range Nuclear Renaissance Index ETF	NUKZ	2.5%
		First Trust North American Energy Infrastructure	EMLP	2.5%
		VanEck Uranium and Nuclear ETF	NLR	2.5%
		State Street Energy Select Sector SPDR ETF	XLE	2.5%

### 3. Индексийн багцын бүрэлдэхүүнийг шинэчлэх (Index reconstitution)

- 3.1 Энэхүү Индексийн аргачлалын 2 дахь хэсэгт тусгасан аргачлалын дагуу Индексийн багцын бүрэлдэхүүнийг жилд нэг удаа шинэчлэн тодорхойлно. Тус шинэчлэлийн зорилго нь Индексийн зорилго, стратегийн хуваарилалт, шалгуур үзүүлэлт болон зах зээлийн нөхцөлтэй нийцсэн бүрэлдэхүүнийг хадгалах явдал юм.
- 3.2 Индексийн багцын бүрэлдэхүүнийг шинэчлэх үнэлгээний огноо (Reconstitution Reference Date) нь хуанлийн жилийн хамгийн сүүлийн арилжааны өдөр байна.
- 3.3 Индексийн багцын бүрэлдэхүүний шинэчлэлийг зарлах өдөр (Reconstitution Announcement Date) нь дараагийн хуанлийн жилийн 3 дахь долоо хоногийн Даваа гараг байна. Тус өдөр нь Индекс тооцогчийн хувьд арилжааны бус өдөр байх тохиолдолд дараагийн арилжааны өдөр тус мэдээллийг зарлана.
- 3.4 Индексийн шинэчилсэн багцын хүчинтэй болох өдөр (Reconstitution Effective Date) нь Индексийн багцын бүрэлдэхүүний шинэчлэлийг зарласан өдрөөс хойших арилжааны 5 дахь өдөр байна. Тус өдөр нь Индекс тооцогчийн хувьд арилжааны бус өдөр байх тохиолдолд дараагийн арилжааны өдөр тус мэдээллийг зарлана.
- 3.5 Индексийн хороо нь энэхүү аргачлалын дагуу Индексийн администраторын тодорхойлсон Индексийн шинэчилсэн багцын бүрэлдэхүүнийг хэлэлцэн, батална.
- 3.6 Индексийн багцын бүрэлдэхүүнийг шинэчлэх (Index reconstitution) хуваарь, холбогдох тодорхойлолтыг доорх хүснэгтэд тусгав.

#### Индексийн багцын бүрэлдэхүүнийг шинэчлэх (Index reconstitution) хуваарь

Үзүүлэлт	Тодорхойлолт
Индексийн багцыг шинэчлэх давтамж (Reconstitution Frequency)	Жилд нэг удаа
Индексийн багцыг шинэчлэх аргачлал (Reconstitution Methodology)	Энэхүү Индексийн аргачлалын 2 дахь хэсэгт тусгасан аргачлалын дагуу Индексийн багцыг шинэчлэн тодорхойлно.
Индексийн багцыг шинэчлэх үнэлгээний огноо (Reconstitution Reference Date)	Хуанлийн жилийн сүүлийн арилжааны өдөр
Индексийн багцын шинэчлэлийг зарлах өдөр (Reconstitution Announcement Date)	Энэ нь дараагийн хуанлийн жилийн 3 дахь долоо хоногийн Даваа гараг байна. Тус өдөр нь Индекс тооцогчийн хувьд арилжааны бус өдөр байх тохиолдолд дараагийн арилжааны өдөр тус мэдээллийг зарлана. Шинэчлэн тодорхойлсон Индексийн багц нь энэхүү аргачлалын 2.1-д тодорхойлсон хувийн жинтэй нийцтэй байна.
Индексийн шинэчилсэн багцын хүчинтэй болох өдөр (Reconstitution Effective Date)	Энэ нь Индексийн багцын шинэчлэлийг зарласан өдрөөс хойших арилжааны 5 дахь өдөр байна. Тус өдөр нь Индекс тооцогчийн хувьд арилжааны бус өдөр байх тохиолдолд дараагийн арилжааны өдөр тус мэдээллийг зарлана.

#### 4. Индексийн багцыг дахин тэнцвэржүүлэх (Index rebalancing)

- 4.1 Индексийн багцыг хагас жил тутамд энэхүү аргачлалын 2.1-т заасан хувь хэмжээнд нийцүүлэн дахин тэнцвэржүүлнэ. Энэхүү үйл ажиллагаатай холбоотойгоор Индексийн бүрэлдэхүүн өөрчлөгдөхгүй бөгөөд зөвхөн Индексийн багцын хувийн жинг тохируулна.
- 4.2 Индекс хороо нь энэхүү аргачлалын дагуу Индексийн администраторын тодорхойлсон Индексийн багцыг дахин тэнцвэржүүлэх төслийг хэлэлцэн, батална.
- 4.3 Индексийн багцыг дахин тэнцвэржүүлэх (Index rebalancing) хуваарь, холбогдох тодорхойлолтыг доорх хүснэгтэд тусгав.

#### Индексийн багцыг дахин тэнцвэржүүлэх (Index rebalancing) хуваарь

Үзүүлэлт	Тодорхойлолт
Индексийн багцыг дахин тэнцвэржүүлэх давтамж (Rebalance Frequency)	Хагас жил тутам
Индексийн багцыг дахин тэнцвэржүүлэх аргачлал (Rebalance Methodology)	Энэхүү Индексийн аргачлалын 2.1-д заасан хувь хэмжээнд нийцүүлэн дахин тэнцвэржүүлнэ.
Индексийн багцыг дахин тэнцвэржүүлэх Үнэлгээний өдөр (Reconstitution Reference Date)	Энэ нь жил бүрийн 6 дугаар сарын болон 12 дугаар сарын сүүлийн арилжааны өдөр байна.
Дахин тэнцвэржүүлсэн Индексийн багцыг зарлах өдөр (Rebalance Announcement Dates)	<b>Жилийн эхний хагас жилийн дахин тэнцвэржүүлэлт:</b> Жил бүрийн 6 дугаар сарын сүүлийн арилжааны өдрөөс хойших арилжааны 3 дахь өдөр;  <b>Жилийн сүүлийн хагас жилийн дахин тэнцвэржүүлэлт:</b> Энэхүү дахин тэнцвэржүүлэлт нь 3 дахь хэсэгт заасан Индексийн багцын бүрэлдэхүүнийг шинэчлэх үйл ажиллагаатай давхардах тул тус үйл ажиллагааны аргачлал, хуваарийг баримтална.
Дахин тэнцвэржүүлсэн Индексийн багцын хүчинтэй болох хугацаа (Rebalance Effective Dates)	Энэ нь дахин тэнцвэржүүлсэн Индексийн багцыг зарласнаас хойших арилжааны 5 дахь өдөр байна.

#### 5. Хуваарьт бус багцын шинэчлэлт болон дахин тэнцвэржүүлэлт

- 5.1 Энэхүү аргачлалын 9-10 дахь хэсэгт заасан зах зээлийн саатал болон/эсхүл давагдашгүй хүчин зүйлс үүссэн тохиолдолд Индексийн багцад хуваарьт бус багцын шинэчлэлт болон/эсхүл дахин тэнцвэржүүлэлт хийх боломжтой.
- 5.2 Энэхүү аргачлалын 5.1-д заасан өөрчлөлтийг Индексийн хороо батална.

#### 6. Индексийг тооцох, нийтлэх

Индексийн төрөл, тооцоолох суурь томъёо

- 6.1 Индекс нь индексийн багцын бүрэлдэхүүн БАС-гуудын үнийн өгөөжийн индекс байна.
- 6.2 Багцад орсон БАС-гуудын индексийг дараах томъёогоор тооцно.

$$Index_t^{MNT} = Index_{t-1}^{MNT} \times \left( 1 + \sum_{i=1}^n w_{i,t-2} \times \frac{P_{i,t-1}^{MNT} - P_{i,t-2}^{MNT}}{P_{i,t-2}^{MNT}} \right)$$

- $t$  : Индексийн Тооцооллын өдөр
- $Index_t^{MNT}$  : Тооцооллын өдрийн төгрөгөөр илэрхийлсэн индекс

- $Index_{t-1}^{MNT}$ : Өмнөх Тооцооллын өдрийн төгрөгөөр илэрхийлсэн индекс
- $w_{i,t-2}$ : Тооцооллын өдрөөс 2 хоногийн өмнөх өдрийн байдлаарх тухайн БАС-гийн Индексийн багцад эзлэх хувийн жин
- $P_{i,t-1}^{MNT} = P_{i,t}^{USD} \times FX_t$ : Индексийн багцад орсон тухайн  $i$  БАС-гийн  $t-1$  өдрийн төгрөгөөр илэрхийлсэн ханш
  - $P_{i,t}^{USD}$ : Индексийн багцад орсон тухайн  $i$  БАС-гийн  $t-1$  өдрийн ам.доллараар илэрхийлсэн ханш
  - $FX_t$ : Тухайн  $t-1$  өдрийн Монголбанкнаас зарласан ам.долларын хаалтын албан ханш
- $n$  – Индексийн багцад орсон БАС-гийн тоо ширхэг.

Суурь огноо, суурь утга

6.3 Индекс эхлэх өдрийн байдлаар индексийн түвшин 1,000.0000 байна..

6.4 Индекс нь таслалаас хойш дөрвөн орны нарийвчлалтай байна.

*Индексийг нийтлэх*

6.5 Индекс тооцогч нь Монгол Улсын арилжааны өдөр бүр Индексийг тооцоолж, өглөөний 10:00 цагт өөрийн цахим хуудас (www.mse.mn)-аараа дамжуулан нийтэд мэдээлнэ (цаашид энэ өдрийг “Тооцооллын өдөр” гэх).

*Монгол болон АНУ-ын арилжааны өдрийн зөрүү*

6.6 Монгол Улс болон АНУ-ын арилжааны өдрүүд зөрөх боломжтой тул үүнтэй холбоотой дараах зохицуулалтыг баримтална. Үүнд:

6.6.1 АНУ-ын хөрөнгийн зах зээл хаалттай ба Монгол Улсын хөрөнгийн зах зээл нээлттэй тохиолдолд Индексийн багц дахь БАС-уудын хамгийн сүүлийн баталгаажсан хаалтын ханшийг ашиглан Индексийг тооцно.

6.6.2 Хэрэв Монгол Улсын хөрөнгийн зах зээл хаалттай ба АНУ-ын хөрөнгийн зах зээл нээлттэй тохиолдолд тухайн өдөр Индексийн түвшинг нийтлэхгүй ба дараагийн Монгол Улсын арилжааны өдөр хамгийн сүүлийн АНУ-ын зах зээлийн хаалтын ханшинд үндэслэн Индексийг тооцно.

*Дахин тооцоолол (Recalculation)*

6.7 Индекс тооцогч нь Индексийн түвшинг үнэн зөв, бодитой тооцоолж, холбогдох мэдээллийг зохих журмын дагуу хадгалах зарчмыг үйл ажиллагаандаа баримтална. Индексийг тооцох явцад дотоод болон гадаад хүчин зүйлээс шалтгаалан алдаа гарах боломжтой ба тус тохиолдолд Индекс тооцогч нь илэрсэн алдааг боломжит хамгийн богино хугацаанд шалган тогтоож, шаардлагатай залруулгыг хийж, холбогдох мэдээллийг зохих журмын дагуу шинэчилнэ.

## **7. Компанийн үйл ажиллагаа (corporate actions and events)**

7.1 Индекс тооцогч нь Индексийн багцад багтсан БАС-г гаргасан этгээдийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсон (Corporate actions and events) тохиолдолд түүний нөлөөллийг Индексийн тооцоололд оруулахдаа Индексийн тасралтгүй байдлыг хангах, эдийн засгийн утгыг алдагдуулахгүй байх зарчмыг баримтална. Индексийн багц дахь хөрөнгөтэй холбоотой Компанийн үйл ажиллагааг дараах зарчмын дагуу зохицуулна. Энэхүү Индексийн аргачлалд дурдаагүй харилцааг Индекс тооцогч болон/эсхүл Индексийн администраторын дотоод журмаар зохицуулна.

БАС-ийн нэгж эрхийг хуваах болон нэгтгэх (Split/Reverse Split)

7.2 БАС-ийн нэгж эрхийг хуваах эсхүл нэгтгэх нь тухайн БАС-ийн эдийн засгийн агуулгыг өөрчлөхгүй тул индексийн жинд өөрчлөлт оруулахгүй.

7.3 Шинэчилсэн зах зээлийн үнийг Индексийн тооцоололд автоматаар ашиглана.

БАС нь нэгтгэх/нийлүүлэх (Merger / Acquisition) ажиллагааны үр дүнд өөрчлөн зохион байгуулагдах

7.4 БАС нь нэгтгэх/нийлүүлэх (Merger / Acquisition) ажиллагааны үр дүнд өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд нэгтгэсэн болон/эсхүл шинээр үүссэн БАС нь дараах шалгуурыг хангаж байвал түүнийг Индексэд үргэлжлүүлэн хадгалах буюу шинээр үүссэн БАС-ийг Индексийн багцад нэмнэ. Үүнд:

7.4.1.1 Нэгтгэсэн болон/эсхүл шинээр үүссэн БАС нь энэхүү Индексийн аргачлалын 2.2-д заасан шаардлагыг хангаж байх;

7.4.1.2 Нэгтгэсэн болон/эсхүл шинээр үүссэн БАС-ийн хөрөнгө оруулалтын стратеги нь өмнөх БАС-тай ижил байх;

7.4.1.3 Нэгтгэсэн болон/эсхүл шинээр үүссэн БАС-ийн хөрвөх чадвар нь тус үйл ажиллагааны өмнөх хөрвөх чадварын үзүүлэлттэй ижил эсхүл илүү өндөр байх.

7.5 Нэгтгэсэн болон/эсхүл шинээр үүссэн БАС нь дээрх шаардлагыг хангахгүй бол түүнийг индексээс хасч, шаардлага хангасан БАС-ийг орлуулах БАС-ийг Индексийн багцад оруулна.

БАС нь хөрөнгийн биржийн бүртгэлээс хасагдах (Delisting)

7.6 БАС нь өөрийн үндсэн хөрөнгийн биржийн бүртгэлээс хасагдсан тохиолдолд Индекс тооцогч нь дараах арга хэмжээг авна. Үүнд:

7.6.1 Тус БАС-ийн сүүлчийн арилжааны өдрийн албан ёсны хаалтын ханшаар тооцож, Индексийн багцаас хасна.

7.6.2 Тус БАС-ийг орлуулах БАС-ийг дараагийн ажлын өдрөөс эхлэн Индексэд оруулна.

БАС татан буугдах

7.7 БАС нь татан буугдсан тохиолдолд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

7.7.1 Тухайн БАС-ийн албан ёсоор зарласан эцсийн цэвэр хөрөнгийн үнэлгээ (NAV) эсхүл эцсийн хаалтын ханшийг ашиглан Индексийн түвшинг тооцоолно.

7.7.2 Тус БАС-ийг Индексийн багцаас хасна.

7.7.3 Тус БАС-ийг орлуулах БАС-ийг дараагийн ажлын өдрөөс эхлэн Индексэд оруулна.

## 8. Индексийн засаглал (index governance)

8.1 Индексийн ил тод, найдвартай ажиллагааг хангах зорилгоор Индексийн засаглал (Index Governance) -ийг бүрдүүлэх ба энэ нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

8.1.1 Индекс тооцогч (Calculation Agent) – Арилжаа эрхлэх байгууллага буюу “Монголын хөрөнгийн бирж” ХК;

8.1.2 Индекс администратор (Index Administrator) – Индексийн багцын бүрэлдэхүүн болон жинг тодорхойлогч этгээд;

8.1.3 Индексийн хороо (Index Committee) – “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Үнэт цаасны индекс тооцох журам”-д заасны дагуу энэхүү Индексийн аргачлалтай холбоотой санал дүгнэлт гаргах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, энэхүү аргачлалын хүрээнд Индекстэй холбоотой шийдвэрийг гаргах чиг үүрэг бүхий хороо.

Индекс тооцогч (Calculation Agent)

- 8.2 “Монголын хөрөнгийн бирж” ХК нь энэхүү Индексийн аргачлалд заасны дагуу Индекс тооцогчийн чиг үүргийг гүйцэтгэх ба үүний хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 8.2.1 Ажлын өдөр бүр Индексийн аргачлал, Индексийн хорооны шийдвэр болон холбогдох бусад журам, гэрээнд нийцүүлэн Индексийн түвшин болон өгөөжийг тооцох, тус мэдээллийг өөрийн албан ёсны цахим хуудас (www.mse.mn)-аар дамжуулан олон нийтэд мэдээлэх;
  - 8.2.2 Индексийн багцыг шинэчилсэн (Reconstitution) болон/эсхүл Индексийн багцыг дахин тэнцвэржүүлсэн (Rebalancing) тохиолдолд Индексийн аргачлал, Индексийн хорооны шийдвэр болон холбогдох бусад журам, гэрээнд нийцүүлэн Индексийн тооцоололд тусгах;
  - 8.2.3 Индексийн багцад багтсан хөрөнгө оруулалтын хэрэгслийг гаргасан этгээдийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсон (Corporate actions and events) эсэхийг тогтмол хянах, тус үйл явдал бий болсон тохиолдолд албан ёсны мэдээлэлд үндэслэн Индексийн хороо болон Индекс администраторт мэдэгдэх, Индексийн аргачлал, Индексийн хорооны шийдвэр болон холбогдох бусад журам, гэрээнд нийцүүлэн Индексийн тооцоололд тусгах;
  - 8.2.4 Индексийн тооцоололд ашиглагдах хөрөнгө оруулалтын хэрэгслийн хаалтын ханшийг албан ёсны баталгаат эх сурвалж (Үүнд, Bloomberg, LSE болон тэдгээртэй адилтгах эх сурвалж байна)-аас, ам.долларын төгрөгтэй харьцах ханшийн өгөгдлийг Монголбанкны албан эх сурвалжаас авах, тус мэдээллийг давхар шалган баталгаажуулах;
  - 8.2.5 Индексийн тооцоололтой холбоотой түүхэн мэдээллийг хадгалах;
  - 8.2.6 Индекс тооцогчийн үйл ажиллагаатай холбоотой судалгаа, тооцоолол болон холбогдох бусад шаардлагатай мэдээллээр Индекс администратор болон Индексийн хороог хангаж ажиллах;
  - 8.2.7 Энэхүү Индексийн аргачлал болон холбогдох бусад журам, гэрээнд заасан бусад чиг үүрэг.
  - 8.2.8 Индекс тооцогч нь энэхүү Индексийн аргачлалд тусгагдсан дүрмийг чанд мөрдөж ажиллана.

#### Индекс администратор (Index Administrator)

- 8.3 Индекс администратор нь энэхүү Индексийн аргачлалд заасны дагуу Индексийн бүрэлдэхүүн, жинг тодорхойлох үйл ажиллагааг хариуцах ба үүний хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 8.3.1 Индексийн аргачлалд нийцүүлэн Индексийн хамрах хүрээ (Index Universe)-г шинэчлэх төслийг бэлтгэн, Индексийн хороонд танилцуулах;
  - 8.3.2 Индексийн аргачлалд нийцүүлэн Индексийн багцыг шинэчлэх (Reconstitution) төслийг бэлтгэн, Индексийн хороонд танилцуулах;
  - 8.3.3 Индексийн аргачлалд нийцүүлэн Индексийн багцыг дахин тэнцвэржүүлэх (Rebalancing) төслийг бэлтгэн, Индексийн хороонд танилцуулах;
  - 8.3.4 Индексийн бүрэлдэхүүнтэй холбоотой санал боловсруулж Индексийн хороонд танилцуулах;
  - 8.3.5 Индекс администраторын үйл ажиллагаатай холбоотой судалгаа, тооцоолол болон холбогдох бусад шаардлагатай мэдээллээр Индекс тооцогч болон Индексийн хороог хангаж ажиллах;
  - 8.3.6 Энэхүү Индексийн аргачлал болон холбогдох бусад журам, гэрээнд заасан бусад чиг үүрэг.
  - 8.3.7 Индекс администратор нь Индекс тооцооллын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй.

#### Индексийн хороо (Index Committee)

Үнэт цаасны индекс тооцох журам

Хуудас 17

- 8.4 Индексийн хороо нь Индекс тооцогчийн “Үнэт цаасны индекс тооцох журам” болон холбогдох эрх бүхий байгууллагын журам, зааврыг үйл ажиллагаандаа баримталж ажиллана.

## 9. Зах зээлийн саатал (market disruption)

- 9.1 Дараах нөхцөл байдлыг зах зээлийн саатал гэж үзнэ. Үүнд:
- 9.1.1 Индексийн багц дахь БАС-ийн нэгж эрхийн арилжаа түүний бүртгэлтэй үндсэн хөрөнгийн бирж дээр түр зогсох;
  - 9.1.2 Тухайн БАС-ийн ханшийн мэдээлэл түүний бүртгэлтэй үндсэн хөрөнгийн бирж дээр нийтлэгдэхгүй байх;
  - 9.1.3 Тухайн БАС-ийн хөрвөх чадвар түүний бүртгэлтэй үндсэн хөрөнгийн бирж дээр огцом буурах.
- 9.2 Зах зээлийн саатлын үед боломжит хамгийн сүүлчийн баталгаажсан ханшийг ашиглана. Ханшийн мэдээлэл байхгүй тохиолдолд өмнөх арилжааны өдрийн хаалтын ханшийг түр ашиглаж болно. Зах зээлийн саатал удаан үргэлжилсэн тохиолдолд Индексийн тогтвортой байдлын хангах зорилгоор Индексийн хороо нь шаардлагатай арга хэмжээг авах шийдвэр гаргана.

## 10. Онцгой нөхцөл байдал (extraordinary events)

- 10.1 Индексийг тооцоолох, шинэчлэх, нийтлэхтэй холбоотой үйл ажиллагаанд дараах даван туулах боломжгүй, урьдчилан тооцоолох боломжгүй, талуудын хяналтаас гадуур үүссэн нөхцөл байдлыг онцгой нөхцөл байдал (extraordinary events) гэж үзэх ба үүнтэй холбоотойгоор Индексийн хороо нь хуваарьт бус шинэчлэл болон/эсхүл дахин тэнцвэржүүлэлт хийж болно. Үүнд:
- 10.1.1 Тухайн БАС нь өөрийн бүртгэлтэй хөрөнгийн биржийн бүртгэлээс хасагдах;
  - 10.1.2 Тухайн БАС татан буугдах;
  - 10.1.3 Тухайн БАС-ийн хөрөнгө оруулалтын бодлого огцом өөрчлөгдөх;
  - 10.1.4 Энэхүү аргачлалын 9 дэх хэсэгт заасан зах зээлийн саатал ажлын 20 (хорь)-оос дээш арилжааны өдрийн хугацаанд үргэлжлэх.
- 10.2 Дээрх нөхцөл байдал үүссэн тохиолдолд Индексийн тогтвортой байдлыг хангах, төлөөлөх чадварыг хамгаалах зорилгоор Индексийн хорооноос дараах шийдвэрийг гаргах боломжтой. Үүнд:
- 10.2.1 Хуваарьт бус багцын шинэчлэлт хийх;
  - 10.2.2 Хуваарьт бус багцын дахин тэнцвэржүүлэлт хийх;
  - 10.2.3 Түр хугацаанд тооцооллын зохицуулалт хийх;
  - 10.2.4 Индексийн хорооны зүгээс шаардлагатай гэж үзсэн бусад шийдвэр.

## 11. Индексийг зогсоох нөхцөлүүд

- 11.1 Индексийн хорооны шийдвэрээр дараах тохиолдлуудад Индекс тооцохыг зогсооно. Үүнд:
- 11.1.1 Олон улсын болон/эсхүл дотоодын зах зээлд онцгой нөхцөл байдал үүсэж, Индексийг цаашид хэвийн тооцоолох боломжгүй болсон;
  - 11.1.2 Индекс администратор болон Индекс тооцогчийн хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээ дуусгавар болсон;
  - 11.1.3 Эрх бүхий зохицуулагч байгууллагаас Индексийн тооцооллыг зогсоох тухай албан шаардлага ирсэн;
  - 11.1.4 Бусад урьдчилан таамаглаагүй, Индексийн үнэн зөв, найдвартай байдалд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдал үүссэн.

## 12. Аудит, архив

- 12.1 Индекс администратор болон Индекс тооцогчийн энэхүү Индексийн аргачлалын дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд жилд нэгээс доошгүй удаа хараат бус, мэргэжлийн байгууллагаар аудит хийлгэнэ.
- 12.2 Индекс администратор нь Индексийн багц бүрдүүлэх, шинэчлэх, дахин тэнцвэржүүлэх болон энэхүү Индексийн аргачлалд заасан бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой бэлтгэсэн тооцоолол, судалгаа, дата мэдээллийг Архивын тухай хуулийн дагуу 5 (тав)-аас доошгүй жил хадгална.
- 12.3 Индекс тооцогч нь Индексийн түвшинг тооцоолох, мэдээлэх болон энэхүү Индексийн аргачлалд заасан бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой бэлтгэсэн тооцоолол, судалгаа, дата мэдээллийг Архивын тухай хуулийн дагуу 5 (тав)-аас доошгүй жил хадгална.

### 13. Хавсралт

Хавсралт №01: Индексийн хамрах хүрээ

№	Стратегийн чиглэл	ETF-ийн нэр	Тикер
<b>1</b>	<b>АНУ-ын зах зээлийн үнэлгээгээр хамгийн том 500 орчим ХК-ийн хувьцааг тэнцүү хувийн жинтэйгээр агуулсан хөрөнгө оруулалт</b>		
1.1	АНУ-ын хамгийн том 500 хувьцаат компанийн хувьцаанд суурилсан хөрөнгө оруулалт	The Goldman Sachs Equal Weight U.S. Large Cap Equity ETF	GSEW
		Invesco S&P 500® Equal Weight ETF	RSP
<b>2</b>	<b>Технологийн салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт</b>		
2.1	Ерөнхий технологийн салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт	The Invesco NASDAQ-100® ETF	QQQM
		Invesco QQQ Trust <sup>SM</sup> , Series 1	QQQ
2.2	Хиймэл оюун ухааны салбар	Robo Global Artificial Intelligence ETF	THNQ
		iShares AI Innovation and Tech Active ETF	BAI
		Roundhill Generative AI & Technology ETF	CHAT
		iShares Future AI & Tech ETF	ARTY
		Global X Artificial Intelligence & Technology ETF	AIQ
		Wisdomtree Artificial Intelligence And Innovation Fund	WTAI
2.3	Чип үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн салбар	State Street SPDR S&P Kensho New Economies Composite ETF	KOMP
		VanEck Semiconductor ETF	SMH
		iShares Semiconductor ETF	SOXX
		First Trust Nasdaq Semiconductor ETF	FTXL
		Invesco PHLX Semiconductor ETF	SOXQ
		Invesco Semiconductors ETF	PSI
2.4	Батлан хамгаалахын салбар	State Street SPDR S&P Semiconductor ETF	XSD
		iShares U.S. Aerospace & Defense ETF	ITA
		Select STOXX Europe Aerospace & Defense ETF	EUAD
		First Trust Indxx Aerospace & Defense ETF	MISL
		Invesco Aerospace & Defense ETF	PPA
		State Street SPDR S&P Aerospace & Defense ETF	XAR
2.5	Роботик болон автоматжуулалтын салбар	Global X Defense Tech ETF	SHLD
		ARK Autonomous Technology & Robotics ETF	ARKQ
		ROBO Global Robotics and Automation Index ETF	ROBO
		Global X Robotics & Artificial Intelligence ETF	BOTZ
		First Trust Nasdaq Artificial Intelligence and Robotics ETF	ROBT
2.6	Кибер аюулгүй байдлын салбар	Amplify Cybersecurity ETF	HACK
		iShares Cybersecurity and Tech ETF	IHAK
		Global X Cybersecurity ETF	BUG
		First Trust NASDAQ Cybersecurity ETF	CIBR

<b>3</b>	<b>Таваарын бүтээгдэхүүнд суурилсан хөрөнгө оруулалт</b>		
3.1	Таваарын бүтээгдэхүүнд суурилсан хөрөнгө оруулалт	Global X Copper Miners ETF	COPX
<b>4</b>	<b>Эрчим хүчний салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт</b>		
4.1	Эрчим хүчний салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт	Range Nuclear Renaissance Index ETF	NUKZ
		First Trust North American Energy Infrastructure	EMLP
		VanEck Uranium and Nuclear ETF	NLR
		Global X Uranium ETF	URA
		Alerian Energy Infrastructure ETF	ENFR
		Global X MLP & Energy Infrastructure ETF	MLPX
		USCF Midstream Energy Income Fund	UMI
		FT Energy Income Partners Strategy ETF	EIPX
		Sprott Uranium Miners ETF	URNM
		iShares Global Energy ETF	IXC
		Vanguard Energy ETF	VDE
		First Trust Global Wind Energy ETF	FAN
		iShares U.S. Energy ETF	IYE
		Sprott Junior Uranium Miners ETF	URNJ
		Invesco S&P 500 Equal Weight Energy ETF	RSPG
		First Trust Energy AlphaDEX Fund	FXN
		Strive U.S. Energy ETF	DRLL
		Energy Select Sector SPDR Fund	XLE
Fidelity MSCI Energy Index ETF	FENY		
iShares Global Clean Energy ETF	ICLN		
First Trust NASDAQ Clean Edge Green Energy Index Fund	QCLN		
Invesco WilderHill Clean Energy ETF	PBW		

Хавсралт №02: Индексийн аргачлалыг баталсан болон нэмэлт, өөрчлөлт оруулсан тухай түүх

Огноо	Өөрчлөлтийн талаарх мэдээлэл
2026/**/**	Индексийг батламжлав.